



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/9/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: myangnbuum@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.2 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.22 № 2/55

танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

005020339

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style, crossing the stamp.

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,964,229.57	58,281,457.99
33	АВЛАГА	00.00	3,140.14
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	3,140.14
35	БАРАА МАТЕРИАЛ	40,964,229.57	58,278,317.85
351	Түүхий эд материал	1,670,200.00	3,823,000.00
35130	Эм боох материал	1,670,200.00	3,823,000.00
354	Хангамжийн материал	39,294,029.57	54,455,317.85
35410	Бичиг хэргийн материал	548,704.05	583,704.05
35420	Аж ахуйн материал	34,687,463.52	50,075,756.80
35460	Хүнсний материал	138,750.00	226,345.00
35470	Бусад хангамжийн материал	3,919,112.00	3,569,512.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	633,971,636.24	619,105,467.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	633,971,636.24	619,105,467.55
392	Биет хөрөнгө	548,646,636.24	533,780,467.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	540,899,133.00	540,899,133.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-30,381,525.44	-40,307,185.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,951,515.00	48,306,861.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,854,833.62	-26,217,602.02
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,912,347.04	30,686,386.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,922,279.74	-21,929,406.19
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	3,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,000,000.00	-3,000,000.00
39217	Ном	2,042,280.00	2,342,280.00
393	Биет бус хөрөнгө	85,325,000.00	85,325,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	85,325,000.00	85,325,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	674,935,865.81	677,386,925.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	284,148.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	284,148.00
413	Өглөг	00.00	284,148.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	284,148.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	674,935,865.81	677,102,777.54
51	Засгийн газрын хувь оролцоо	674,935,865.81	677,102,777.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249,677,773.32	249,677,773.32
51101	Өмч: - төрийн	249,677,773.32	249,677,773.32
512	Хуримтлагдсан үр дүн	102,833,494.65	100,666,582.92
51210	Өмнөх үеийн үр дүн	102,833,494.65	102,833,494.65
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	2,166,911.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	528,091,587.14	528,091,587.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	674,935,865.81	677,386,925.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	471,793,240.00	455,066,603.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,388,500.00	8,200,162.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,388,500.00	8,200,162.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	108,289,340.00	57,338,441.75
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	358,115,400.00	389,528,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,572,740.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,572,740.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,716,600.00	57,338,441.75
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,716,600.00	57,338,441.75
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	474,230,097.00	452,613,825.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	474,230,097.00	452,613,825.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,640,009.50	438,338,865.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,351,314.33	297,010,696.46
210101	Үндсэн цалин	208,021,614.33	288,830,219.00
210102	Нэмэгдэл	54,306,500.00	4,616,767.46
210104	Урамшуулал	19,023,200.00	3,563,710.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,498,265.67	38,592,104.83
210201	Тэтгэврийн даатгал	24,352,469.94	27,024,564.56
210202	Тэтгэмжийн даатгал	2,793,896.76	2,986,908.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,224,877.74	2,382,806.74
210204	Ажилгүйдлийн даатгал	539,841.42	562,343.86
210205	Эрүүл мэндийн даатгал	5,587,179.81	5,635,481.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,521,267.00	57,122,589.75
210301	Гэрэл, цахилгаан	1,448,459.00	1,998,873.75
210302	Түлш, халаалт	43,858,792.00	46,884,420.00
210303	Цэвэр, бохир ус	10,214,016.00	8,239,296.00
210304	Байрны түрээс	3,000,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,675,128.78	8,830,965.04
210401	Бичиг хэрэг	1,076,100.00	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	769,329.50	817,245.32
210404	Ном, хэвлэл	18,900.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	544,800.00	442,501.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,141,500.00	4,871,150.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	66,000.00
210408	Бараа материал акталсны зардал	374,499.28	1,119,468.72
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	00.00	14,600.00
2105	Нормативт зардал	14,855,487.00	11,630,315.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	670,300.00	2,073,000.00
210502	Хоол, хүнс	14,185,187.00	9,439,665.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	117,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,230,900.00	2,699,700.00
210604	Урсгал засвар	2,230,900.00	2,699,700.00
2107	Томиллолт, зочны зардал	132,000.00	90,000.00

**Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210702	Дотоод албан томилолт	132,000.00	90,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	631,700.00	937,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	331,700.00	347,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,743,946.72	21,425,094.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	636,493.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	773,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,743,946.72	20,015,301.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,590,087.50	14,274,959.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,622,740.00	130,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,315,340.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,257,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000.00	130,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,295,333.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,295,333.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,672,014.50	14,144,659.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,672,014.50	14,144,659.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-2,436,857.00	2,452,778.57
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	151,749.85	285,866.84
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	151,749.85	285,866.84
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-151,749.85	-285,866.84
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-2,588,606.85	2,166,911.73

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,677,773.32	528,091,587.14	-100,244,887.80	677,524,472.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-16,560,125.10	-16,560,125.10
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,677,773.32	528,091,587.14	-116,805,012.90	660,964,347.56
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,688,606.73	-1,688,606.73
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,677,773.32	528,091,587.14	-102,833,494.65	674,935,865.81
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	249,677,773.32	528,091,587.14	-102,833,494.65	674,935,865.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,677,773.32	528,091,587.14	-102,833,494.65	674,935,865.81
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,166,911.73	2,166,911.73
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,677,773.32	528,091,587.14	-100,666,582.92	677,102,777.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	466,404,740.00	446,866,441.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	466,404,740.00	446,866,441.75
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	358,115,400.00	389,528,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,572,740.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,572,740.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,716,600.00	57,338,441.75
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,716,600.00	57,338,441.75
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	458,248,440.00	443,706,441.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,248,440.00	443,706,441.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	400,557,752.50	429,431,482.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,297,613.27	297,010,696.43
210101	Үндсэн цалин	207,967,913.27	214,966,922.19
210102	Нэмэгдэл	54,306,500.00	55,390,527.00
210104	Урамшуулал	19,023,200.00	26,653,247.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,488,795.73	38,595,245.00
210201	Тэтгэврийн даатгал	24,343,000.00	27,148,945.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,793,896.76	2,861,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,224,877.74	2,289,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	539,841.42	572,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,587,179.81	5,723,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,421,267.00	56,838,441.75
210301	Гэрэл, цахилгаан	1,448,459.00	1,998,873.75
210302	Түлш, халаалт	43,758,792.00	46,600,272.00
210303	Цэвэр, бохир ус	10,214,016.00	8,239,296.00
210304	Байрны түрээс	3,000,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,522,529.50	14,973,546.32
210401	Бичиг хэрэг	135,500.00	217,200.00
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	1,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	769,329.50	894,245.32
210404	Ном, хэвлэл	18,900.00	348,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	544,800.00	442,501.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,304,000.00	12,070,700.00
2105	Нормативт зардал	15,646,147.00	10,736,260.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,070,300.00	610,800.00
210502	Хоол, хүнс	13,125,647.00	9,541,860.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	450,200.00	583,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,751,900.00	4,499,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,521,000.00	1,800,000.00
210604	Урсгал засвар	2,230,900.00	2,699,700.00

**Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2107	Томилолт, зочны зардал	132,000.00	90,000.00
210702	Дотоод албан томилолт	132,000.00	90,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	631,700.00	1,245,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	331,700.00	655,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	350,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,665,800.00	5,442,193.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,399,993.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,665,800.00	1,042,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,690,687.50	14,274,959.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,723,340.00	130,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,315,340.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	11,257,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,600.00	130,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,295,333.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,295,333.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,672,014.50	14,144,659.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,672,014.50	14,144,659.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,156,300.00	3,160,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,156,300.00	3,160,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,156,300.00	3,160,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,156,300.00	3,160,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,156,300.00	3,160,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-8,156,300.00	-3,160,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	452,993,900.00	432,721,782.50	20,272,117.5	95.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,993,900.00	432,721,782.50	20,272,117.5	95.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	452,863,600.00	432,591,482.50	20,272,117.5	95.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,159,600.00	297,010,696.43	1,148,903.6	99.61
210101	Үндсэн цалин	217,834,700.00	214,966,922.19	2,867,777.8	98.68
210102	Нэмэгдэл	53,431,500.00	55,390,527.00	-1,959,027.0	103.67
210104	Урамшуулал	26,893,400.00	26,653,247.24	240,152.8	99.11
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,631,500.00	38,595,245.00	3,036,255.0	92.71
210201	Тэтгэврийн даатгал	30,185,200.00	27,148,945.00	3,036,255.0	89.94
210202	Тэтгэмжийн даатгал	2,861,600.00	2,861,600.00	0.0	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,289,200.00	2,289,200.00	0.0	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	572,300.00	572,300.00	0.0	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,723,200.00	5,723,200.00	0.0	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	62,965,900.00	56,838,441.75	6,127,458.3	90.27
210301	Гэрэл, цахилгаан	5,734,600.00	1,998,873.75	3,735,726.3	34.86
210302	Түлш, халаалт	46,759,500.00	46,600,272.00	159,228.0	99.66
210303	Цэвэр, бохир ус	10,471,800.00	8,239,296.00	2,232,504.0	78.68
2104	Хангамж, бараа материалын зардал	15,556,100.00	14,973,546.32	582,553.7	96.26
210401	Бичиг хэрэг	217,200.00	217,200.00	0.0	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,402,300.00	894,245.32	508,054.7	63.77
210404	Ном, хэвлэл	365,100.00	348,900.00	16,200.0	95.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	442,501.00	57,499.0	88.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,071,500.00	12,070,700.00	800.0	99.99
2105	Нормативт зардал	20,081,600.00	10,736,260.00	9,345,340.0	53.46
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	610,800.00	610,800.00	0.0	100.00
210502	Хоол, хүнс	18,886,800.00	9,541,860.00	9,344,940.0	50.52
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	584,000.00	583,600.00	400.0	99.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,359,700.00	7,359,700.00	0.0	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,660,000.00	4,660,000.00	0.0	100.00
210604	Урсгал засвар	2,699,700.00	2,699,700.00	0.0	100.00
2107	Томилолт, зочны зардал	121,600.00	90,000.00	31,600.0	74.01
210702	Дотоод албан томилолт	121,600.00	90,000.00	31,600.0	74.01
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,245,400.00	1,245,400.00	0.0	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	655,400.00	655,400.00	0.0	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	0.0	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.0	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5742200.00	5742193.00	7.0	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,700,000.00	4,699,993.00	7.0	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,042,200.00	1,042,200.00	0.0	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130300.00	130300.00	0.0	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	130,300.00	130,300.00	0.0	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	130,300.00	130,300.00	0.0	100.00

**Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	452,993,900.00	432,721,782.50	20,272,117.5	95.52
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	389,528,000.00	375,383,340.75	14,144,659.3	96.37
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	389,528,000.00	375,383,340.75	14,144,659.3	96.37
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	63,465,900.00	57,338,441.75	6,127,458.3	90.35
132001	Орон нутгийн төсвөөс	63,465,900.00	57,338,441.75	6,127,458.3	90.35
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00	25.00	0.0	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.0	100.00
620003	Үйлчлэх ажилтан	08.00	08.00	0.0	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	220.00	220.00	0.0	100.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	220.00	220.00	0.0	100.00
630002	Хувийн ЕБС	220.00	220.00	0.0	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.00	25.00	0.0	100.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	14.00	14.00	0.0	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	11.00	0.0	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд албан хаагчдын цалин, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын тайланд залруулан зөв мэдээлэх, төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан зааврын дагуу анхан шатны баримтыг хөтлөх, түүнд тавих нягтлан бодогчийн хяналтыг сайжруулах, тооллогын бүртгэлийг үндэслэн тооцоо бодсон актыг үйлдэж байх зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг Б.Мөнхнасан, 2 дугаар гарын үсгийг 1-2 дугаар сард Б.Оюундарь, 3-12 дугаар сард Л.Даваа нар зурж, нярваар Х.Хүрэлбаатар ажиллажээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэг нь тайлант онд 7 зорилтыг дэвшүүлэн, 25 орон тоотой ажиллаж, дунд, ахлах, бэлтгэл бүлэгт 143 хүүхэд хамрагдахаас танхимаар 93, цахимаар 50 хүүхэд хамрагдсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй ба 2021 онд аймгийн хэмжээнд мөрдөгдөх 300.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг авсан байна.

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 474,230.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,742.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,793.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 452,329.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,523.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,618.6 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 677,386.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос

**Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2,451.1 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	3	5
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,964.2	58,281.5	17,317.2
Авлага	-	3.1	3.1
Бараа материал	40,964.2	58,278.3	17,314.1
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	633,971.6	619,105.5	(14,866.2)
Үндсэн хөрөнгө	712,680.3	711,109.7	(1,570.6)
Хуримтлагдсан элэгдэл	(78,708.6)	(92,004.2)	(13,295.6)
Нийт хөрөнгө	674,935.9	677,386.9	2,451.1
Өр төлбөр	-	284.1	284.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	674,935.9	677,102.8	2,166.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	674,935.9	677,386.9	2,451.1

сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 58,278.3 мянган төгрөг болж өмнөх оноос 17,314.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 34,497.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 5,925.2 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа 21,974.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, байгууллагын даргын 2021.05.28-ний өдрийн А/25 дугаар тушаалаар 1,119.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталж, Баянхонгор сумын Засаг даргын захирамжаар Баян-Ойт цэцэрлэгт 14.6 мянган төгрөгийн хүнсний материалыг шилжүүлсэн байна.

Оны эхэнд бүртгэлтэй 712,680.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж төсвийн хөрөнгөөр 2,860.0 мянган төгрөгийн ногоо хэрчигч, 300.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг худалдан авсныг орлогоор бүртгэн, аймгийн ЗДТГ-аас 550.0 мянган төгрөгийн өнгөт принтер, 1,725.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер ирснийг хөрөнгөд бүртгэсэн ба Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.10.15-ний өдрийн 116 дугаар тогтоолоор 16 нэр төрлийн 7,005.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан оны эцэст 711,109.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 2,166.9 мянган төгрөгөөр өсч 677,102.8 мянган төгрөг болсон байна.

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэг улсын төсвөөс авах санхүүжилт өмнөх оноос 32,161.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 452,993.9 мянган төгрөг болсон нь цалингийн зардал, хангамж, бараа материалын зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэг 2021 оны төсвийн төлөвлөлтийг 581,144.4 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн хуваарийг анх 474,284.6 мянган төгрөгөөр баталсан ба тайлант хугацаанд 2021 оны 4 дүгээр сард 460,986.4 мянга, 7 дугаар сард 471,284.6 мянга, 11 дүгээр сард 452,993.9 мянган төгрөг болж, анх батлагдсан төсвөөс 21,290.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Анхны батлагдсан төсөв	2021 оны 12 сард хийсэн тодотгосон төсөв
581,144.4	452,993.9

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэг өөрийн орлогын төлөвлөгөөгүй, тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр авахаар батлагдсан 389,528.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн, орон нутгийн төсвөөс авахаар батлагдсан 63,465.9 мянган төгрөгийг 6,127.5 мянган төгрөгөөр дутуу авч, нийт 446,866.4 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 432,721.8 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 14,144.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт төсөв байхгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны 12 дугаар сард хоолны зардлын хэмнэлтийн 7,964.0 мянган төгрөгийн 5,464.0 мянган төгрөгийг бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс авахад, 2,500.0 мянган төгрөгийг цалингийн зардалд зарцуулахаар төсөвт зохицуулалт хийж, цалингийн зардлыг зарцуулалгүй оны эцэст төсөвт төвлөрүүлжээ.

“Тулга төхөөрөмж” ХХК-аас 2,860.0 мянган төгрөгийн ногоо хэрчигч, 1,800.0 мянган төгрөгийн ногоо хэрчигчийн комплекс худалдан авсан байна.

Оны эцэст хоолны зардлын хэмнэлтийг багаж техник хэрэгсэл худалдан авах зардалд тодотгуулан “Окфил эко” ХХК-аас нэг бүр нь 106.0 мянган төгрөгийн үнэ бүхий 44 ширхэг агаар шүүгчийг 4,664.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2021 онд нийт 11 бүлэг зорилтын хүрээнд 85 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг дээд шатны байгууллагаас одоогоор үнэлээгүй ба төлөвлөгөөний биелэлтийг байгууллага 97% гэж тайлагнасан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг шалгав.

Тус байгууллага нь 2021 онд нийт 572,209.6 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхийг бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, ТБОНӨХБАҮХАТХ болон Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын зарим чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй нь холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэн зөвлөмжийг хүргүүлэв.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, менежментийн захидлаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгч, шалгагдагч байгууллага зөвлөмжийн биелэлтийг 2021.06.15-ний өдрийн 49 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,879.4 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн тайланд 1,325.1 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 554.3 мянган төгрөгийн зөрчилд байгууллагын удирдлагад 3 зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн санхүүгийн тайланд 1,325.1 мянган төгрөгийн дараах 4 алдааг залруулав.

- Өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлангаас үр дүнгийн тайланг 900,0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.
- Халаалтын гэрээ байгуулсан "Рашаант хайрхан" ХХК нь халаалтын зардалд 9 дүгээр сард 284.1 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн байхад санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй.
- Нягтлан бодогч ариутгалын зардлын 120.0 мянган төгрөгийг бараа материалын орлогод бүртгэсэн.

- Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн эрхлэгчийн 2021.05.28-ний өдрийн А/25 дугаар тушаалаар 30 нэр төрлийн 1,119.5 мянган төгрөгийн эд хөрөнгийг актлах тушаал гарсан байхад нягтлан бодогч 1,140.5 мянган төгрөгийн бараа материал зарлагадан 21.0 мянган төгрөгөөр зөрсөн нь нягтлан бодогч зарцуулсан бараа материалыг акталснаар бүртгэсэн байна.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Балансын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Нягтлан бодогч 6,7-р сард тус тус 2 албан хаагчийн цалинг нийгмийн даатгалын мэдээнд 539.4 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Албан хаагчдын дутуу мэдээлсэн 539.4 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын тайланд залруулан зөв мэдээлэх

2. **Зардлын холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт: Тайлант онд тогтмол зардалд 66,216.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байхад 56,838.4 мянган төгрөгийг зарцуулж “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.8 дахь “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-оос доошгүй хувийн хэмнэлт гаргах”, бичиг хэргийн зардалд батлагдсан 217.2 мянган төгрөгийг зарцуулж тогтоолын 1.9 дэх “Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах” заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

3. **Зардлын холбоотой асуудал**

3.1. Илрүүлэлт: Нярав бичиг хэргийн материалын тайланд орлогыг 15.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, шаардах хуудсыг ажилтан тус бүрээр бичүүлээгүй, тооллогын комиссын жилийн эцсийн тооллогын бүртгэлийг хангалтгүй хөтөлсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан зааврын дагуу анхан шатны баримтыг хөтлөх, түүнд тавих нягтлан бодогчийн хяналтыг сайжруулах, тооллогын бүртгэлийг үндэслэн тооцоо бодсон актыг үйлдэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэг	7	1,879.4	4	1,325.10	0	0	0	-	3	554.3

---oOo---